



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/706

Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь дууссан иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг харгалзан Өв Усжуулагч ХК (2015447)-ийн эзэмшил Арвайхээр сумын 5 дугаар багийн барилга-21 тоотод байрлах үйлдвэрлэлийн зориулалттай 15486м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жил, Нацагийн Баярсайхан (ЙР61060178)-ийн эзэмшил Арвайхээр сумын 8 дугаар багийн 35 дугаар гудамж, 14 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 378м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 30 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь сунгагдсан иргэн, аж ахуйн нэгжтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101343